

МОНГОЛЫН УРЛАГИЙН ЗӨВЛӨЛ

2017

ЖИЛИЙН ТАЙЛАН

МОНГОЛЫН
УРЛАГИЙН
ЗӨВЛӨЛ

Чингэлтэй дүүрэг
Жуулчны гудамж
Дельта төв, 4-р давхар
402 тоот
Улаанбаатар 15170
Монгол улс
www.artscouncil.mn

Агуулга

Монголын Урлагийн Зөвлөлийн тэргүүний мэндчилгээ 4

Урлагийн хөтөлбөр 6

Олон нийтийн урлагийн боловсролын хөтөлбөр 23

Соёлын өвийн хөтөлбөр 34

Хөгжлийн хөтөлбөр 41

МУЗ-ийн хандивлагчид 45

МУЗ-ийн төслийн хамтрагчид 46

МУЗ-ийн хүндэт Эрхэм хандивлагчийн мэндчилгээ. 47

МУЗ-ийн гишүүд. 48

Удирдах зөвлөл 49

Хороодын гишүүд 50

Ажилтнууд 51

МОНГОЛЫН УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН ТЭРГҮҮНИЙ МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм танд Монголын Урлагийн Зөвлөлийн (МУЗ)-ийн 2017 оны жилийн тайланг хүргэж байгаадаа баяртай байна.

2017 он МУЗ-ийн 15 жилийн ой тохиосон онцлог жил болж өнгөрлөө. Ойн хүрээнд МУЗ-ийн өнгөрсөн хугацаанд Монголын соёл урлагийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр, ололт амжилтыг олон нийтэд өргөнөөр таниулан сурталчилсан “Хариуцлагатай, Бүтээлч, Олон талт хамтын ажиллагааны 15 жил” аяныг санаачлан бүтэн жилийн туршид амжилттай зохион байгууллаа.

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд МУЗ нь соёл урлагийн, нийгмийн салбарт үзүүлж буй үр дүн, ач холбогдол, хүний нөөц, удирдлага, санхүүжилтийн хувьд төлөвшин, үндэсний болон олон улсын түвшинд хөтөлбөрүүдээ тогтвортой хэрэгжүүлж ирсэн. Зөвлөл нь 2017 оны 12 сарын байдлаар 6,5 гаруй сая ам. долларын санхүүжилтийг бүрдүүлж, Монголын соёл урлагийн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулсан байна.

2017 оны хувьд Австрали, Бельги, Бразил, Герман, Замби, Солонгос, Тайвань, Францын соёл урлагийн байгууллага, уран бүтээлчидтэй хамтын ажиллагааг өргөжүүлэхээс гадна, уран бүтээлчдийн чадавхийг дээшлүүлэх, дэмжих, соёлын өвийг хадгалан хамгаалах, олон нийтийн урлагийн боловсролоор дамжуулан бүтээлч иргэнийг төлөвшүүлэхэд соёл урлагийн гүйцэтгэх үүргийг таниулан сурталчлахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

МУЗ нь 2017 оны 12-р сарын байдлаар нийт 338,390 ам.долларын сан бүрдүүлснээс 37 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн, 20 гаруй соёл урлагийн байгууллагатай ажиллаж, 640 гаруй уран бүтээлчдийг хамруулан, 29,350 орчим хүнд хүрч ажилласан бол 677,894 хүнд олон нийтийн мэдээллийн сувгаар үйл ажиллагаагаа сурталчилан хүргэсэн байна.

Эцэст нь бидний үйл ажиллагааг үргэлж дэмжин, соёл урлагийн хөгжилд хувь нэмрээ оруулж, хамтран ажилласан бүхий л байгууллага, хувь хүн, хамтрагч, анд нөхөд, гишүүд, сайн дурын ажилтнууддаа гүн талархал илэрхийлье!

Доктор Нацагийн Жанцанноров
МУЗ-ийн Тэргүүн
Ардын жүжигчин, Төрийн хошой шагналт
Хөгжмийн зохиолч, хөгжим судлаач

УРЛАГИЙН ХӨТӨЛБӨР

УРЛАГИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго

Монголын соёл урлагийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар тэдгээрийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

2017 оны үйл ажиллагааны товч танилцуулга

2017 онд Урлагийн хөтөлбөр нь нийт 19 төслийг хэрэгжүүлж, 500 гаруй уран бүтээлчдийг хамруулан 9000 үзэгчид олон нийтэд хүрч ажилласан ба 4 төслийг шинээр санаачлан амжилттай хэрэгжүүлсэн байна.

Тус хөтөлбөрийн 2017 оны онцлох төслөөр хоёр дахь удаагаа зохион байгуулагдаж буй “Улаанбаатар” олон улсын медиа урлагийн наадмыг нэрлэж болно. “Ул мөр” сэдвийн хүрээнд Монголын Уран зургийн галерейд нэг сарын хугацаанд зохион байгуулсан энэхүү наадам нь бид хойч үедээ ямар ул мөр үлдээх тухай асуудлыг дэвшүүлсэн видео, фото, инстоляци, дуу, хөгжмийг найруулан бүтээсэн нийлмэл буюу медиа урлагийг олон нийтэд танилцуулснаараа онцлог болсон юм. Наадамд Австрали, Монгол, Герман, Филиппин, Солонгос, Чех зэрэг орны 8 уран бүтээлч оролцсон.

СОЁЛ УРЛАГИЙН ЗАЛУУ МАНЛАЙЛАГЧ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Соёл урлагийн салбарын залуу удирдагчдын чадавхийг дээшлүүлэх, тэдний хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь 2017-2018 онд “Соёл урлагийн залуу манлайлагч” хөтөлбөрийг АНУ дахь МУЗ-ийн дэмжлэгтэйгээр 10 дах жилдээ амжилттай зохион байгуулж байна. Энэ удаа кино, дүрслэх урлаг, тайз дэлгэцийн урлаг, соёлын өв, хэвлэл мэдээлэл зэрэг соёл урлагийн салбарын нийт 22 залуу уран бүтээлчдийг сургалтанд хамруулж, чадавхийг дээшлүүлэн, ирээдүйн манлайлагчдыг бэлтгэж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд “Манлайлал”, “Төслийн менежмент”, “Маркетинг”, “Стратеги төлөвлөлт”, “Сан бүрдүүлэлт”, “Зохиогчийн эрх ба оюуны өмч”, “Соёлын бодлого”, “Байгууллагын засаглал” зэрэг цуврал 19 сургалтыг олон улсын болон дотоодын мэргэжилтнээр удирдуулан зохион байгуулсан. Мөн хөтөлбөрийн оролцогчид МУЗ-ийн үйл ажиллагаанд хамрагдаж, туршлага судлан, нийгэмд чиглэсэн, бүтээлч бичил төслийг санаачлан хэрэгжүүлж, хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн билээ.

Төслийн хамтрагч

UB Inn Hotel & Gallery

Төслийн хандивлагч

Уолтер Женкинс, МУЗ-ийн Дэд тэргүүн
АНУ дахь МУЗ



“ГЭРЭЛТ МОРЬД” ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Монголын соёл урлагийг дэлхийд сурталчлан таниулах, уран бүтээлчдийн бүтээн туурвих үйл явцыг дэмжих.

Төслийн танилцуулга

МУЗ нь ХААН Банк Сан, АНУ дахь МУЗ-тэй хамтран Питер Морроу агсны гэгээн дурсгалд зориулан “Гэрэлт морьд” төслийг санаачлан хэрэгжүүллээ. Уг төсөл нь “Гэрэлт морьд” олон улсын хөтөлбөр, уран бүтээлийн тэтгэлэгт уралдаан гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

“Гэрэлт морьд“ олон улсын тэтгэлэгт хөтөлбөрт уран бүтээлч Б.Бат-Эрдэнэ сонгогдон, Нидерландын Вант Улсын Хааг хотноо зохион байгуулагдсан дэлхийн 40 гаруй орны олон улсын медиа урлагийн наадамтай хамтран ажилладаг Европын хамгийн том наадмуудын нэг болох TodaysArt олон улсын наадамд оролцож, өөрийн шинэ медиа бүтээлийг дэлгэн танилцуулсан ба ХААН Банкны галерейд “Тэнгэрт нэгэн удаа” үзэсгэлэнгээ толилуулсан.

Харин “Гэрэлт морьд” тэтгэлэгт уралдааныг АНУ дахь МУЗ-ийн дэмжлэгтэйгээр жил бүр уламжлал болгон зарлах болсон ба уг тэтгэлэгийн эзнээр уран бүтээлч Б.Мөнхзул шалгарч, шинэ виртуал бүтээлээ туурвих боломжтой болсон.

Төслийн хамтрагч

ХААН Банк галерей
TodaysArt медиа урлагийн наадам

Төслийн хандивлагч

ХААН Банк сан
АНУ дахь МУЗ
Уолтер Женкинс, МУЗ-ийн Дэд тэргүүн



“УЛААН ГЭР” ГАЛЕРЕЙ

Төслийн зорилго

“Улаан Гэр” галерейн зорилго нь уран бүтээлчдийг дэмжих, бизнесийн байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар МУЗ-ийн тогтвортой хөгжлийг дэмжих, сан бүрдүүлэхэд оршино.

Төслийн танилцуулга

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд “Улаан гэр” галерей нь нүүдлийн галерейгаар дамжуулан залуу уран бүтээлчдийн үзэсгэлэнг зохион байгуулж, “Улаан гэр” урлангаар хангах хөтөлбөрийг санаачлан уран бүтээлчдийг дэмжин, үйл ажиллагаагаа тогтвортойгоор үргэлжлүүлж ирсэн.
2017 оны 5 сард Монголиан Пропертис ХХК-ний дэмжлэгтэйгээр МУЗ-ийн “Улаан гэр” галерей Олимпик Резиденст байрлах шинэ байранд нүүн орж, уран бүтээлчдийн бүтээн туурвих үйл явцыг дэмжин ажиллах болсон.
“Улаан гэр” галерей нь “Монголиан Пропертис” ХХК-ийн Олимпик резиденсэд үүд хаалгаа нээснээс хойш нийт 25 гаруй уран бүтээлчидтэй хамтран ажилласан байна. Үүнд:
Уран бүтээлчдийн хамтарсан үзэсгэлэн болон Бу.Бадралын “Дэвж үзээгүй далавч” үзэсгэлэн, Г.Гантулгын “Оршихуй ...Цагаан уул” үзэсгэлэн, Х.Уганбаярын “Зоригдолын орон” бие даасан үзэсгэлэн, О.Ням-Очирын “Шастир” уран бичлэгийн үзэсгэлэн, Б.Бат-Эрдэнийн “Тэнгэрт нэгэн удаа” медиа үзэсгэлэнг амжилттай зохион байгуулж нийт 1500 орчим хүнд үйл ажиллагаагаа таниулан сурталчилсан байна.

Төслийн хамтрагч

“Монголиан Пропертис” ХХК





“AAN-ACM УЛААН ГЭР” УРЛАНГААР ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Уран бүтээлчдийн чадавхийг бэхжүүлэх, бүтээн туурвих үйл явцыг дэмжих.

Төслийн танилцуулга

МУЗ нь “Азийн Урлагийн Мэдээ” сэтгүүлтэй хамтран уран бүтээлчдийн бүтээн туурвих үйл явцыг дэмжих зорилготой “ANN-ACM Улаан Гэр” урлангаар хангах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. 2017 онд уран бүтээлч Д.Үүрийнтуяа, У.Нарбаясгалан, Бу.Бадрал, М.Мөнхжаргал нар урлангаар хангах хөтөлбөрт шалгаран оролцсон бөгөөд Д.Үүрийнтуяа, М.Мөнхжаргал нар том хэмжээний уран бүтээлийг монгол зургийн аргаар туурвиж дуусгасан харин У.Нарбаясгалан “Дотоод үйлдэл” хэмээх бие даасан үзэсгэлэндээ зориулан уран бүтээлээ туурвисан. Харин уран бүтээлч Бу.Бадрал нь урлангаар хангах хөтөлбөрийн хугацаанд бүтээн туурвисан 20 гаруй бүтээлээрээ “Дэвж үзээгүй далавч” үзэсгэлэнг “Улаан гэр” галерейд гаргасан байна.

Төслийн хандивлагч

Иен Финдлей Браун, “Азийн урлагийн мэдээ” сэтгүүлийн эрхлэгч



“SMART” ГЭРЭЛ ЗУРГИЙН УРЛАНГААР ХАНГАХ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Гэрэл зурагчдын чадавхийг дээшлүүлэх, олон улсын уран бүтээлчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, урлагийн байгаль орчин болон орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь гэрэл зурагчдын чадавхийг дээшлүүлэх, олон улсын уран бүтээлчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, урлагийн байгаль орчин болон орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх зорилгоор Швейцар улсын Уулархаг Нутгийн Тогтвортой Хөгжлийг Дэмжих Сантай (FDDM) хамтран “SMArt” урлангаар хангах хөтөлбөрийг 2 дахь удаагаа хэрэгжүүлэхээр 2017 оны 11 сард зарласан билээ. Тус хөтөлбөрт 20 гэрэл зурагчин материалаа өгснөөс Б.Тамир шалгаран, гурван сарын хугацаатай Швейцарийн Бэллвалд тосгонд байрлан, олон улсын гэрэл зурагчидтай хамт тэндхийн хүрээлэн буй орчин, байгалийн гэрэл зургийг дурандаа буулган гаргах ба урлангийн хугацаанд буулгасан гэрэл зургуудаар Бэллвалд тосгон болон Улаанбаатар хотод тус тус гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулна.

Төслийн хамтрагч

SMArt, Артбелвард Нийгэмлэг

Төслийн хандивлагч

Швейцар улсын Уулархаг Нутгийн Тогтвортой Хөгжлийг Дэмжих Сан





“САЛХИЙГ МЭДЭР” НҮҮДЛИЙН УРЛАН ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Уран бүтээлчдэд шинэ уран бүтээл туурвих орон зайг бий болгох, хөгжмийн салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь нүүдлийн урлан хөтөлбөрийг 10 дах жилдээ “Салхийг мэдэр” сэдвийн дор орчин үеийн хөгжмийн урлагийн чиглэлээр зохион байгуулж байна. Тус хөтөлбөр нь Монгол-Солонгосын хөгжимчдийн хамтын ажиллагааг дэмжих, харилцан туршлага солилцох, шинэ хөгжим туурвих боломжийг олгодог онцлогтой.

“Салхийг мэдэр” нүүдлийн урланд Морин хуурын чуулга, “Арга билэг” хамтлаг, “Түмэн эх” чуулгын нийт 4 уран бүтээлч, Солонгосын орчин үеийн хөгжмийн “wHOOL” хамтлагийн 8 гишүүн оролцож, Монголын говийн үзэсгэлэнт газруудаар аялан, гоцлол, цөөхүүл хоршил гэх мэт бүрэлдэхүүнээр чөлөөт хэлбэрээр зохиомжлон хөгжимдөж, байгалиас онгод урам авч туурвисан орчин үеийн шинэ хөгжмийн тоглолтоо 9 сарын 18-нд толилууллаа. Тоглолтын хөгжмийн үндсэн бүрэлдэхүүнд морин хуур, лимбэ, аман хуур, хөөмий, уртын дуу болон Солонгосын үндэсний хөгжмүүд, цахилгаан гитар, даралтат хөгжим зэрэг Монгол, Солонгос, Европ хөгжмүүд багтсан.

Төслийн хамтрагч

Солонгосын Урлагийн Зөвлөл
“Mongolian Quest” ХХК
On & Off Production

Төслийн хандивлагч

Солонгосын Урлагийн Зөвлөл



БНСУ-ЫН АЗИЙН СОЁЛЫН ТӨВИЙН СУУРЬШИН СУРАЛЦАХ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Олон улсын уран бүтээлчдийн бүтээн туурвих үйл явцыг дэмжих, хамтарсан бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь БНСУ-ын Азийн Соёлын Төвийн “ACT Center Visiting Creators in Lab” хэмээх суурьшин суралцах хөтөлбөрт кино найруулагч, медиа уран бүтээлч Ш.Ихбаярыг хамруулан 3 сарын хугацаатай Гуанжу хотод өөрийн шинэ медиа уран бүтээлээ туурвих боломжийг олгосон.

Ш.Ихбаяр нь 2017 оны 4-7 сарын хооронд Гуанжугийн Азийн Соёлын Төвийн техникийн баг болон хувь уран бүтээлчидтэй хамтран ажиллаж, өөрийн “Цөм ухамсар” интерактив видео бүтээлээ туурвисан ба уг бүтээлээ Улаанбаатар олон улсын медиа урлагийн наадамд толилуулж, эцсийн хувилбарыг 2017 оны 7 сард тус төвийн үзэсгэлэнгийн танхимд олон нийтэд хүргэсэн болно.

Төслийн хамтрагч

БНСУ-ын Азийн Соёлын Төв





“АЛТАЙ ФОРУМ” ОЛОН УЛСЫН СУУРЬШИН СУРАЛЦАХ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Алтайн язгуурын хэлтэй улс орнуудын харилцаа холбоог бэхжүүлэх, соёлын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь Бүгд Найрамдах Киргиз Улсын Соёл, Мэдээлэл, Аялал жуулчлалын яамтай хамтран уран бүтээлч Ё.Далх-Очир, Т.Энхболд нарыг нүүдлийн соёл иргэншлийн Курманжан Датка төвийн олон улсын богино хугацааны хөтөлбөрт урин оролцуулав.

Тус хөтөлбөр нь 2017 оны 8-р сарын 20-30 хүртэл үргэлжилсэн бөгөөд уран бүтээлчдийн бүтээн туурвих үйл явцыг дэмжин, хамтран бүтээл туурвих, туршлага солилцох боломжийг олгосон юм.

Төслийн хамтрагч

Курманжан Датка төв

Төслийн хандивлагч

Бүгд Найрамдах Киргиз Улсын Соёл, Мэдээлэл, Аялал жуулчлалын яам



“ДЭЛХИЙН МОДНЫ ӨДӨР” ОЛОН УЛСЫН НААДАМ

Төслийн зорилго

Уран бүтээлчдийн чадавхийг дээшлүүлэх, олон улсын уран бүтээлчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, урлагийн байгаль орчин болон орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, монголын соёл урлагийг олон улсад сурталчлах.

Төслийн танилцуулга

МУЗ нь модон сийлбэрч уран бүтээлчдийн чадавхийг дээшлүүлж, олон улсын уран бүтээлчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, урлагийн байгаль орчин болон орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, монголын урлагийг олон улсад сурталчлах зорилготойгоор Олон Улсын Мод Хамгаалах Соёлын Нийгэмлэгийн “Дэлхийн Модны Өдөр” олон улсын наадамтай хамтран ажиллаа. Тус наадам нь 2017 онд АНУ-ын Калифорни мужид болсон ба мод хүн төрөлхтөний амьдрал, тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг олон нийтэд таниулах зорилготойгоор жил бүр өөр улсад зохион байгуулагддаг соёл урлагийн арга хэмжээ юм. Уг наадамд уран бүтээлч О.Энхтайван уригдан оролцож өөрийн уран бүтээлээ олон улсын хамтарсан үзэсгэлэнд танилцуулан, модон сийлбэрийн амьд үзүүлбэрт оролцож, уран бүтээлчидтэй хамтарсан бүтээл урласан юм.

Төслийн хамтрагч

Олон Улсын Мод Хамгаалах Соёлын Нийгэмлэг



“ХОТЫН ТҮҮХ БА ШИЛЖИЛТ, ХӨДӨЛГӨӨН” МЕДИА ТӨСӨЛ

Төслийн зорилго

Архивт хадгалагдаж буй дүрс бичлэгт суурилсан уран бүтээлээр дамжуулан хотын түүх, нийгэм, соёлын өөрчлөлт, цаг үеийн шилжилт хөдөлгөөнийг залуу үеийнхэнд бүтээлчээр танилцуулах.

Төслийн танилцуулга

МУЗ нь Архивын Ерөнхий Газартай хамтран архивт хадгалагдаж буй 16мм, 35мм-ийн хальсны дүрс бичлэгт суурилсан экспериментал, абсракт видео бүтээл туурвих хотын түүх ба шилжилт хөдөлгөөн төслийг хэрэгжүүлсэн.

Төслийн зочин багш Молдав улсын уран бүтээлч, куратор Стефан Русу болон АНУ-ын кино найруулагч, медиа уран бүтээлч Жон Дэвис нар 14 медиа уран бүтээлч, телевизийн найруулагч, продюсер болон архивын ажилтнуудад хоёр долоо хоногийн медиа урлагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар залуу уран бүтээлчдэд 16мм, 35мм-ийн хальсны дүрсийг дижитал хэлбэрт шилжүүлэх, хуучны дүрс бичлэгт тулгуурлан экспериментал видео бүтээл туурвих аргачлал, олон улсын туршлагаас хуваалцсан болно. Мөн эдгээр бүтээлийг “I Cinema” кино театрт олон нийтэд толилуулан танилцуулсан.

Төслийн хамтрагч

Архивын Ерөнхий Газар
iCinema кино театр
СУИС-ийн радио телевиз, медиа урлагийн сургууль
UB Inn Hotel & Gallery

Төслийн хандивлагч

АНУ дахь МУЗ – TMU



“УЛААНБААТАР” ОЛОН УЛСЫН КИНО НААДАМ

Төслийн зорилго

Кино урлагийн салбарын олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, дэлхийн сор болсон артхаус бүтээлийг Монголын үзэгчдэд хүргэх замаар тус салбарын хөгжлийг дэмжих.

Төслийн танилцуулга

МУЗ нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, Нийслэлийн Соёл Урлагийн Газар, Монголын Кино Урлагийн Зөвлөлтэй хамтран “Улаанбаатар” олон улсын IX кино наадмыг 2017 оны 10-р сарын 10-15-нд Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Уг наадмаар дамжуулан дэлхийн шилдэг Канн, Берлин, Венец, Торонто, Сандэнс, Пусан зэрэг олон улсын кино наадамд шалгарсан Австрали, Бразил, Бельги, Герман, Замби, ОХУ, Франц, Тайвань зэрэг орны кино бүтээлийг олон нийтэд толилуулан, уран бүтээлчидтэй хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Наадмын онцлох орноор Америкийн Нэгдсэн Улс сонгогдсон ба “Америкийн Кино Өдөрлөг”-ийг 2017 оны 10-р сарын 11-нд Америкийн Элчин Сайдын Яамтай хамтран зохион байгуулсан. Мөн наадмын онцлох найруулагчаар Бельгийн кино найруулагч Питер Бросенсийг урин оролцуулж, түүний кино найруулагч Д.Төрмөнхтэй хамтран бүтээсэн “Нохойн Орон”, “Хадаг” болон “Тав дахь Улирал” кино бүтээлүүдийг олны хүртээл болгож, найруулагч Питер Бросэнстай нээлттэй ярилцлагыг хийсэн.

Наадмын хүрээнд Монголын уран бүтээлчдийн чадавхийг дээшлүүлэх, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, кино бүтээлээ олон улсад түгээхэд дэмжлэг үзүүлэх зорилготой “Улаанбаатар Кино Форум”, “Кино яармаг”-ийг тус тус зохион байгуулсан.

УБОУКН-ын “Үзэгчдийн нэрэмжит шагнал”-ыг уламжлал болгон тодруулсан ба энэ удаагийн шагналыг ОХУ-ын найруулагч Андрей Звягинцевийн “Хайр үгүй” кино, 2-р байранд АНУ-ын “Ахмад Гайхамшиг”, 3-р байранд ХБНГУ-ын “Тони Эрдманн” кино тус тус шалгарсан.

Төслийн хамтрагч

Монголын Кино Урлагийн Зөвлөл
Монгол Фильм Студи
Тэнгис кино театр
ICinema кино театр
Corporate Hotel & Convention Center
Culture Distributer ХХК
Гүрү Медиа ХХК
Алтан Хальс Холбоо
Монгол Контент ХХК
Дижитал Контент ХХК
Анкор төв
UB Inn Hotel & Gallery
Broadway Сүлжээ Ресторан

Төслийн хандивлагч

Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
Нийслэлийн Соёл Урлагийн Газар
АНУ-ын Элчин Сайдын Яам
Францын Элчин Сайдын Яам
Гёте Институт Монголиа
Австралийн Элчин Сайдын Яам






Улаанбаатар
ОЛОН УЛСЫН
КИНО НААДАМ
2017.10.10-15








Улаанбаатар
ОЛОН УЛСЫН
КИНО НААДАМ



“УЛААНБААТАР” ОЛОН УЛСЫН МЕДИА УРЛАГИЙН НААДАМ

Төслийн зорилго

Соёлын олон төрлийг хөгжүүлэх, техник технологийн дэвшилд тулгуурласан дэлхийн шилдэг бүтээлийг Монголын үзэгчдэд хүргэх, дүрслэх урлагийн салбарын олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь “Улаанбаатар” олон улсын медиа урлагийн наадмыг 2017 оны 6 сарын 9-нөөс 7 сарын 9-ний хооронд Монголын уран зургийн галерейд хоёр дах жилдээ зохион байгуулсан. Наадам нь “Ул мөр” сэдвийн хүрээнд нэг сарын хугацаанд зохион байгуулагдсан ба бидний хойч үедээ ямар ул мөр үлдээх вэ асуултыг хөндөж, дэвшилтэт техник технологид тулгуурласан видео, фото, инстоляци, дуу, хөгжимтэй найруулан бүтээсэн нийлмэл буюу медиа урлагийн бүтээлийг олон нийтэд танилцуулснаараа онцлог болсон юм. Наадамд Австрали, Монгол, Герман, Филиппин, Солонгос, Чех зэрэг орны 8 уран бүтээлч оролцсон.

Төслийн хамтрагч

Монголын уран зурийн галерей
Гёте Институт Монголиа
Рэд Херо ХХК
СУИС

Төслийн хандивлагч

АНУ-ын Элчин Сайдын Яам
Төгөлдөр сан
ХАС Банк
Porsche Mongolia
Mongolian Quest ХХК
АПУ ХК















“ӨРНӨ ДОРНЫН АЯЛГУУ” АНУ-ЫН “BREAK OF REALITY” БОЛОН МОРИН ХУУРЫН ЧУУЛГЫН ХАМТАРСАН ТОГЛОЛТ

Төслийн зорилго

Америкийн Нэгдсэн Улс Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ойн хүрээнд АНУ-ын Элчин Сайдын Яам, Гадаад Харилцааны Яам, Монголын Урлагийн Зөвлөл хамтран АНУ-ын “Break of Reality” цөөхүүл хөгжмийн хамтлагийг Монголд урьж, “Өрнө Дорнын Аялгуу” тоглолтыг хамтран зохион байгуулсан.

Энэхүү тоглолтыг АНУ-ын “Break of Reality” болон МУ-ын Морин Хуурын Чуулга хамтран тоглосноороо онцлог байлаа. АНУ-ын Засгийн Газраас 2015 онд “Хөгжмийн элч” хамтлагаар сонгогдсон тус хамтлаг Монгол дахь аялан тоглолтынхоо хүрээнд Монголын театр, чуулгын мэргэжлийн хөгжимчид ба утсан хөгжмийн мэргэжлээр суралцаж буй оюутан сурагчдад сургалт явуулж, харилцан туршлага солилцсон.

Мөн олон нийтийн хөгжмийн боловсролыг дээшлүүлэх, орчин цагийн дэлхийн хөгжмийн хөгжлийг таниулах зорилгоор Монголын Хүүхдийн Ордны Их танхимд ЕБС-ийн сурагчдад үнэ төлбөргүй тоглолтыг зохион байгуулсан.



“ХУГАРААГҮЙ НОЁН НУРУУ” ХҮНДЭТГЭЛИЙН ТОГЛОЛТ

Төслийн зорилго

Төрийн хошой шагналт, Монголын улс төрийн нэрт зүтгэлтэн, зууны манлай роман “Тунгалаг Тамир”-ыг туурвин бүтээсэн эрдэмтэн, зохиолч төр нийгмийн зүтгэлтэн Чадраабалын Лодойдамбын мэндэлсний 100 жилийн ойд зориулан хүндэтгэлийн тоглолт зохион байгуулах.

Төслийн танилцуулга

2017 онд Чадраабалын Лодойдамбын мэндэлсний 100 жилийн ой тохиосон онцлог жил болж өнгөрлөө. Ойн хүрээнд олон үйл ажиллагаа зохиогдсоны нэг нь “Хугараагүй ноён нуруу” ойн хүндэтгэлийн тоглолтыг Чадраабалын Лодойдамба сан, Тахько ХК, Монголын Урлагийн Зөвлөл, Дуурь Бүжгийн Эрдмийн Театр болон соёл, урлагийн төлөөлөгч нар хамтран зохион байгууллаа.

Төслийн хамтрагч

Чадраабалын Лодойдамба сан
Дуурь Бүжгийн Эрдмийн Театр

Төслийн хандивлагч

Тахь-Ко ХХК



УРЛАГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

ОЛОН НИЙТИЙН УРЛАГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго:

Урлагийн боловсролоор дамжуулан үндэсний болон хүмүүний нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэгч иргэд, нийгмийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах.

2017 оны үйл ажиллагааны товч танилцуулга

2017 онд МУЗ-ийн Олон Нийтийн Урлагийн Боловсролын хөтөлбөр нь соёл урлагийн хувь хүн болон нийгмийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, түүний ач холбогдлыг таниулан сурталчлах зорилго бүхий 7 төслийг хэрэгжүүллээ.

Олон Нийтийн Урлагийн Боловсролын хөтөлбөр нь АНУ дахь МУЗ-ийн дэмжлэгтэйгээр хүүхэд залуучуудын урлагийн боловсролыг дэмжих чиглэлээр 18 оюутанд сургалтын тэтгэлэг олгож, соёл ба боловсролын олон улсын хөтөлбөрт ЕБС-ийн ахлах ангийн 30 сурагчийг хамруулсан байна.

Мөн ХАС Банкны дэмжлэгээр 300 гаруй бага болон дунд сургуулийн хүүхдийг бүтээлч үйл ажиллагаанд оролцуулж, дүрслэх урлагийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулсан. МУЗ нь Тахь-Ко ХХК-ны дэмжлэгээр Ж.Чулууны нэрэмжит Өсвөрийн хөгжимчдийн 11 дүгээр олон улсын уралдааныг ивээн тэтгэж, авьяаслаг залуу уран бүтээлчдийг дэмжихэд хувь нэмрээ оруулаа.

Хөтөлбөр нь урлагаар дамжуулан нийгэмд тулгамдаж буй олон талт асуудлыг хөндөн хэлэлцэх, ардчиллын үнэт зүйлс, шударга ёс, тогтвортой хөгжлийг хангахад соёл урлагийн салбарын нөлөөллийг нэмэгдүүлэх чиглэлээр “Урлагтай Яриа” нийтлэл, “Re-Imagine Mongolia” гар урлалын төслийг зохион байгуулж, нийт 5,000 орчим хүнийг төслийн үйл ажиллагаанд хамруулан, 10,000 гаруй хүнд телевиз, цахим сүлжээ, сонин, сэтгүүлээр дамжуулан мэдээ, мэдээллээ хүргэсэн байна.

Мөн МУЗ-ийн уламжлал болгон хэрэгжүүлж ирсэн үндэсний өв соёлыг олон нийтэд таниулан сурталчлах зорилготой “Соёлын Наадам” төслийг 10 дахь жилдээ амжилттэй зохион байгуулсан.

“УРЛАГТАЙ ЯРИА” ЦУВРАЛ НИЙТЛЭЛ

Төслийн зорилго

Урлагаар дамжуулан, нийгэмд тулгамдаж буй олон талт асуудлын талаарх мэдлэг, мэдээллийг олон нийтэд хүргэх, олон нийтийн урлагийн боловсролыг дээшлүүлэх.

Төслийн танилцуулга

2016 онд “Соёлын бөмбөрцөг”, “Дэнж хотойлгосон Монгол наадам дэлхийд соёл урлагаараа Монголоо гоёдог”, Re-Imagine Mongolia буюу “Хог хаягдлаас урлаг руу”, “Урлагийн үнэ цэнэ”, “Ирээдүй дэх өнгөрсөн цаг: ул мөрөө бүтээхүй”, “Венецийн биенналь 2017: Урлаг мандтугай!”, “Дуураймал аз жаргал”, “Үндсэрхэг үзлийн комплекс”, “Artificial Intelligence: Абсолют байж чадсан нь амьд үлдэнэ” зэрэг урлагаар дамжуулан нийгэм, соёлын салбарт тулгамдсан асуудлыг хөндсөн 9 нийтлэлийг бэлтгэн, www.artscouncil.mn, www.news.mn, өдөр тутмын “Өнөөдөр” онлайн www.unuudur.mn сонин, долоо хоног тутмын “Гэрэг”, “Тойм” сэтгүүлд нийтлэж, 2000 гаруй хүнд мэдээллээ хүргэсэн байна.

Төслийн хамтрагч

“Өнөөдөр” сонин
“Гэрэг” сэтгүүл
“Тойм” сэтгүүл
www.news.mn
нийтлэлчид



СОЁЛЫН НААДАМ

Төслийн зорилго

Монголын нүүдэлчний өв соёл, ардын урлагийг гадаад дотоодод сурталчлах, наадмын соёлын үйлчилгээ, соёл урлагийн арга хэмжээний хүрээг өргөтгөх.

Төслийн танилцуулга

МУЗ нь Соёл Урлагийн Их Сургууль, Солонгосын METAA компанитай хамтран Улсын Их Баяр Наадмын үеэр наадамчин олон, хүүхэд залуус, жуулчдад Монголын нүүдэлчний өв соёл, ардын урлагийг таниулан сурталчлах зорилготой “Соёлын Наадам” нүүдэлчний урлагийн наадмыг Хүй Долоон Худагт арав дах жилдээ амжилттай зохион байгууллаа. “Соёлын Наадам”-ын үеэр “Монголын нэг өдөр” гар урлалын өртөө, “Сэрсэн тал” ардын урлагийн тоглолтыг тус тус зохион байгуулж, 10,000-15,000 гаруй наадамчин олон болон жуулчдад үндэсний урлагийг таниулан сурталчиллаа.

Төслийн хамтрагч

МУ-ын Соёл Урлагийн Их Сургууль
Улсын Их Баяр Наадам Зохион Байгуулах Комисс










“RE-IMAGINE MONGOLIA” ГАР УРЛАЛЫН ТӨСӨЛ

Төслийн зорилго

Урлагаар дамжуулан бага орлоготой өрхийн эмэгтэйчүүдийг чадавхижуулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь “Re-Imagine Mongolia” гар урлалын төслийг санаачлан Сонгинохайрхан дүүргийн 3-р хорооны 20 эмэгтэйг хамруулан, 5 уран бүтээлч-багшийн удирдлаган дор 2 сарын турш цаасан шуумал урлалын аргаар шинэ бүтээл, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн урлахад сурган, түүнийгээ худалдан борлуулахад нь дэмжлэг үзүүлэн, өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд нь хувь нэмэр оруулав.

Төсөлд хамрагдсан эмэгтэйчүүдийн цаасан шуумлын бүтээлийг олон нийтэд таниулах, борлуулах үйлчилгээг Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музейтэй хамтран зохион байгууллаа.

Цаасан шуумал урлаачид бүтээлээ худалдан борлуулахаас гадна өөрсдийн амьдарч буй хорооны бусад эмэгтэйчүүд, хүүхдүүдэд зааж сургах, байгууллага хамт олонд гэрээгээр багшлах зэрэг бүтээлч ажлуудыг үргэлжлүүлэн өрнүүлж байна.

Төслийн хамтрагч

СХД-ийн 3-р хорооны иргэд “Inspired living” урлан

Төслийн хандивлагч

Швейцарийн хөгжлийн агентлаг










“МИНИЙ АЗ ЖАРГАЛЫН МОРЬ” ХҮҮХДИЙН ЗУРГИЙН УРАЛДААН БА ҮЗЭСГЭЛЭН

Төслийн зорилго

Хүүхэд залуучуудын урлагийн боловсролыг дэмжих, ирээдүйн бүтээлч иргэнийг төлөвшүүлэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь 2017 онд ХАС Банктай хамтран хүүхэд багачуудын урлагийн боловсролыг дэмжих зорилготой “Миний аз жаргалын морь” хүүхдийн уран зургийн төслийг хэрэгжүүлэв. Төслийн хүрээнд “Миний аз жаргалын морь” сэдэвт зургийн уралдааныг олон нийтэд нээлттэйгээр зарлан, уралдаанд ирсэн 250 хүүхдийн бүтээлээр Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музейд үзэсгэлэн зохион байгуулж, 50 хүүхдийг уран зургийн сургалтанд хамруулсан байна. Үзэсгэлэнг нийтдээ 2000 гаруй хүн үзэж сонирхсон ба 5000 гаруй хүнд мэдээ, мэдээллийг цахим хэлбэрээр хүргэсэн байна.

Төслийн хамтрагч

Занабазарын нэрэмжит Дүрслэх Урлагийн Музей

Төслийн хандивлагч

Хас Банк



“ОРИФЛЭЙМ МОНГОЛ” ХХК-НЫ НЭРЭМЖИТ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Оюутнуудын мэргэжлээрээ суралцах хүсэл эрмэлзлэлийг тэтгэн дэмжих, ирээдүйн урлагийн манлайлагчдыг бэлтгэх.

Төслийн танилцуулга

МУЗ нь Монгол Улсын Консерваторид амжилттай суралцаж буй санхүүгийн чадамжгүй оюутнуудын сурах хүсэл эрмэлзлэлийг тэтгэн дэмжих, ирээдүйн урлагийн манлайлагчдыг бэлтгэх зорилготой нэг жилийн сургалтын тэтгэлэг олгох хөтөлбөрийг зургаа дах жилдээ зохион байгуулсан. Хөтөлбөрт Монгол Улсын Консерваторийн 15 шилдэг оюутан хамрагдаж, бүтэн жилийн сургалтын тэтгэлэгээ хүлээн авлаа.

Төслийн хамтрагч
Монгол Улсын Консерватори

Төслийн хандивлагч
Орифлэйм Монгол ХХК



“ЛЮБИ–ЖЕНКИНС” МОНГОЛ-АМЕРИКИЙН СУРАГЧ СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго

Монгол-Америкийн соёл, боловсролын солилцоог хөгжүүлэх замаар ирээдүйн манлайлагчдыг бэлтгэх.

Төслийн танилцуулга

2017 онд Зориг Сантай хамтран Монгол-Америкийн соёл, боловсролын солилцоог хөгжүүлэх замаар ирээдүйн манлайлагчдыг бэлтгэх, дэмжих зорилготой Монгол-Америкийн хүүхэд залуучуудын соёлын солилцооны хөтөлбөрийг тав дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ. 2016-2017 оны ээлжит хөтөлбөрт ЕБС-ийн ахлах ангийн 40 сурагч хамрагдаж, үндэсний өв соёл, соёлын олон төрөл зүйлст суралцсаны зэрэгцээ ардчилал, иргэний нийгмийн талаарх мэдлэгээ дээшлүүлж, хамтарсан бичил төсөл хэрэгжүүлэн туршлага хуримтлууллаа. Мөн амжилттай суралцсан сурагчид хоёр орны соёл, иргэний боловсролыг танин мэдэх аялалд хамрагдсан болно.

Төслийн зохион байгуулагч

Зориг Сан

Төслийн хандивлагч

АНУ дахь МУЗ

Уолтер Женкинс, МУЗ-ийн Дэд тэргүүн



АМЕРИКИЙН БАЛЕТЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Төслийн зорилго
Ирээдүйн балетын бүжигчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх замаар Монголын сонгодог бүжгийн хөгжилд хувь нэмэр оруулах.

Төслийн танилцуулга
МУЗ нь “Глобал Эдюкэйшн” ХХК-ны санаачилсан ирээдүйн балетын бүжигчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилготой Америкийн балетын хөтөлбөрийг тав дах жилдээ дэмжиж хамтран ажиллаа. 2017 оны хөтөлбөрт Номадик Балет Продакшны зохион байгуулсан сонгодог бүжгийн улсын уралдааны 3 шилдэг оролцогч, тус продакшны бүжигчин багш хамрагдаж, АНУ-ын Колорадо Балетын Академийн зуны эрчимжүүлсэн сургалтанд бүрэн тэтгэлэгтэйгээр суралцан, мэргэжлийн ур чавдараа дээшлүүлэх боломжийг олголоо.

Төслийн хамтрагч
“Глобал Эдюкэйшн” ХХК
Номадик Балет Продакшн
Колорадогийн Балетын Академи, АНУ

Төслийн хандивлагч
АНУ дахь МУЗ
Уолтер Женкинс, МУЗ-ийн Дэд тэргүүн



СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР

СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго

Соёлын өвийг хадгалж хамгаалахад дэмжлэг үзүүлэх, түгээн дэлгэрүүлж үр ашгийг нь нэмэгдүүлэх.

2017 оны үйл ажиллагааны товч танилцуулга

МУЗ-ийн Соёлын өвийн хөтөлбөр нь Монголын биет ба биет бус соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах, олон нийтэд соёлын өвийн талаар сурталчлан мэдлэг олгоход чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг билээ. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд төр захиргааны, мэргэжлийн соёл урлагийн байгууллага ба гадаад дотоодын бизнесийн байгууллагын соёлын өвийг хамгаалахад чиглэсэн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж ирлээ.

2017 онд хөтөлбөрийн хүрээнд соёлын өвийг таниулан сурталчлах, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр цогц ажил хийлээ. Тухайлбал: “Үндэсний бичиг соёлын өв”, Чойжин ламын сүм музейн нөлөөллийн судалгааны төслийг үргэлжлүүлэн, “Монгол соёл-youtube суваг” төслийн хүрээнд айрагны соёлыг сурталчлах видео, жуулчдад зориулсан өв соёлоо таниулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлж, “Данзанравжаа олон улсын яруу найргийн наадам”, Канадын уугуул иргэдийн хөгжмийн “Крис Дерксен Трио” хамтлагийг тоглолтыг тус тус зохион байгууллаа.

“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛЫН ӨВ” ЦОМОГ

Төслийн зорилго

Монголын оюуны өв соёлыг таниулан сурталчилах.

Төслийн танилцуулга

Баримтат өвийг гадаад дотоодод сурталчлан таниулах зорилгоор МУ-ын Үндэсний Номын Сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй 118 үнэт ховор номын танилцуулга бүхий цомгийг англи, монгол хэл дээр 1000 хувь хэвлэн нийтэлж, Үндэсний Номын Сангийн брэнд бүтээгдэхүүнийг бий болголоо. Цомог нь гэрэл зураг, тайлбар текстээр дамжуулан үндэсний ба дэлхийн хосгүй үнэт ном судар, баримт бичгийн түүхэн ач холбогдлыг уншигчдад ойлгуулахын зэрэгцээ эрдэнийн чулуугаар бичих, цаас бүтээх, өнгө будаг гаргаж будах онцгой арга барил зэрэг Монголчуудын ном судар бүтээх уламжлалт урлахуйн ухааны тухай мэдлэгийг олгож, дахин давтагдашгүй урлагийн сод бүтээлийн үнэ цэнийг таниулан сурталчиллаа.

Төслийн хамтрагч

БСШУСЯ
МУ-ын Үндэсний Номын Сан

Төслийн хандивлагч

Ш.Норжинбат, Делоитт Онч Аудит ХХК



“МОНГОЛЫН СОЁЛ YOUTUBE СУВАГ” БОГИНО ХЭМЖЭЭНИЙ ЦУВРАЛ ВИДЕО БҮТЭЭЛ

Төслийн зорилго

Соёлын биет бус өвийг таниулан сурталчилах.

Төслийн танилцуулга

Монголын соёлын биет бус өвийг цахим орчинд видео цувралаар гадаад дотоодын үзэгчдэд таниулан сурталчилах зорилгоор “Монголын соёл Youtube суваг” төслийг санаачлан анхны богино хэмжээний сурталчилгааны видео бүтээлийг “Гүрү медиа” ХХК-ийн уран бүтээлчид бүтээж, Монголын уламжлалт исэг цагаан идээ айрагний соёл, уламжлалт ахуй, тоглоом наадгай, зан үйлийг сурталчилан таниулах, хөхүүрийн айраг бэлдэж хэрэглэдэг уламжлалт арга, ёсыг сэргээн хөгжүүлэх, өвлөн уламжлах, түгээн дэлгэрүүлэхийн ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлав.

Цуврал видео бүтээлийн эхний дугаарыг “Айрганд шингэсэн бидний түүх” нэртэйгээр Youtube дээр байршуулав.

Төслийн хамтрагч

“Гүрү Медиа” ХХК

Төслийн хандивлагч

Ш.Норжинбат, “Делоитт Онч Аудит” ХХК



ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА

Төслийн зорилго

Түүх соёлын дурсгалт барилгын хадгалалт хамгаалалтын менежментийг сайжруулах, Чойжин ламын сүм музейн хамгаалалтанд нөлөөлөх байгалийн ба нийгмийн хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах.

Төслийн танилцуулга

Түүх соёлын дурсгалт барилгын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, цаашдын сэргээн засварлалтын ажилд бэлтгэх зорилгоор Чойжин ламын сүм музейн соёлын өвийн нөлөөллийн судалгааг БСШУСЯ ба Соёлын өвийн төв, Чойжин ламын сүм музейтэй хамтран хэрэгжүүллээ. 2017 онд барилга архитектурын, соёлын өвийн мэргэжилтнүүд нийгмийн ба байгалийн шинжлэх ухааны мэргэжилтнүүдийн хамтаар түүх соёлын дурсгалт барилгад сөргөөр нөлөөлөх байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс, орчин нөхцлийн эрсдлийг 9 төрлийн судалгаагаар тодорхойлж, барилгын бүтцийн гэмтлийн хэмжээг тогтоон хадгалалт хамгаалалт сэргээн засварлалтад шаардлагатай зөвлөмж, хадгалалт хамгаалалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулан гаргалаа.

Төслийн хамтрагч

БСШУСЯ
Соёлын Өвийн Төв
ШУТИС Геологи, уул уурхайн сургууль
ШУА-ийн Ерөнхий ба Сорилын Биологийн Хүрээлэн
ШУА-ийн Түүх, Археологийн хүрээлэн
Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэн
Чойжин ламын сүм музей
Херитейж ХХК

Төслийн хандивлагч

Рожер Перри, Австрали улс



ДЭЛХИЙН ЯРУУ НАЙРГИЙН ӨДРҮҮД

Төслийн зорилго

Утга зохиолын салбарт олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, соёлын аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, ноён хутагт Данзанравжаагийн өв соёлын дурсгалыг олон улсад сурталчилах.

Төслийн танилцуулга

Монголын Соёл Яруу Найргийн Академийн санаачлагаар “Байгалийн оюун санаа ба хүмүүний сэтгэлийн байгаль” хэмээх агуулгын дор байгалийн ба түүх соёлын өв санд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, говийн ноён хутагт Данзанравжаагийн өвийг сурталчлах зорилгоор Монголд анх удаа Данзанравжаа олон улсын яруу найргийн наадам ба Дэлхийн яруу найрагчдын 37-р их хурлыг зохион байгууллаа. Дэлхийн яруу найргийн өдрүүд нь 40 орчим орны 200-аад нэрт яруу найрагч, зохиолч, нийтлэлч, орчуулагч, урлаг соёлын зүтгэлтнийг хамруулсан урлагийн ба соёлын аялал жуулчлалын томоохон арга хэмжээ болсон юм.

Дэлхийн яруу найргийн өдрүүдийн хүрээнд гадаад, дотоодын уран бүтээлчдийн хамтарсан бичиг соёл, дүрслэх урлагийн үзэсгэлэн, номын нээлт, яруу найргийн уншлагууд байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газар болох Хамрын хийд, энергийн төв болон улсын чанартай музейд олон нийтэд нээлттэй боллоо.

Төслийн хамтрагч

НЗДТГ
Дорноговь аймгийн ЗДТГ
Нью Жуулчин ХХК

Төслийн хандивлагч

Монголын Соёл Яруу найргийн Академи



“CRIS DERKSEN TRIO” ХАМТЛАГИЙН ТОГЛОЛТ

Төслийн зорилго

Соёлын олон төрөл зүйлсийг сурталчлах, Канадын уугуул иргэдийн уламжлалт соёлыг Монголд танилцуулах.

Төслийн танилцуулга

Канадын уугуул иргэн уран бүтээлч Крис Дерксены “Cris Derksen Trio” хамтлагын тоглолтыг Хас Банк санхүүжүүлэн Канадын Урлагийн зөвлөл дэмжиж, Монголын Урлагийн Зөвлөл (МУЗ) тоглолтыг зохион байгууллаа.

“Cris Derksen Trio” хамтлагийн виолончель хөгжимчин, хөгжмийн зохиолч Крис Дерксен, уламжлалт Хүүп бүжигчин Нимки Осавамик, бөмбөрчин хөгжмийн зохиолч, продюсер Морган Доктор нар нийслэлийн Улаанбаатар чуулгын хөгжимчид, Хөсөгтөн хамтлагийн морин хуурч, хөөмэйч О.Чулуунбаатартай хамтран Канадын индиан угсаатны хөгжим, бүжгийг Монголын үндэсний хөгжим орчин үеийн электрон хөгжимтэй хослуулсан тоглолтыг толилууллаа. “Cris Derksen Trio” хамтлаг мэргэжлийн ба орчин үеийн хөгжим зохиогчдод зориулсан сургалт, Монгол-Канадын хамтарсан хөгжмийн тоглолт зохион байгуулснаар хоёр орны уран бүтээлчид өөрсдийн үндэсний соёл, мэргэжлийн туршлагаас харилцан суралцахаас гадна Монгол үзэгч сонсогчдод Канадын уугуул иргэдийн уламжлалт соёл ба Канадын орчин үеийн хөгжмийн урлагийн хөгжлийн түвшин, шинэ чиг хандлагыг таниулсан юм.

Төслийн хамтрагч

Канадын элчин сайдын яам
Херитейж ХХК

Төслийн хандивлагч

Хас Банк



ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн зорилго

Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон дотоодын бизнесийн байгууллагатай хамтран ажиллах замаар МУЗ-ийн тогтвортой хөгжлийг дэмжих, сан бүрдүүлэх.

2017 оны үйл ажиллагааны товч танилцуулга

2017 онд МУЗ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагаа тогтворжин, харилцагч болон гишүүн байгууллагын итгэлийг хүлээсэн, захиалагчийн сонирхол, таашаалд нийцсэн арга хэмжээг МУЗ-ийн Гишүүнчлэл, “Соёлын довтолгоон” Та амар, бид хийе! үйлчилгээгээр дамжуулан зохион байгууллаа.



“СОЁЛЫН ДОВТОЛГООН” ТА АМАР, БИД ХИЙЕ! ҮЙЛЧИЛГЭЭ

Хөгжлийн хөтөлбөр нь “Соёлын довтолгоон” Та амар, бид хийе! байгууллага хамт олны хүлээн авалт, арга хэмжээг зохион байгуулдаг үйлчилгээг хэрэгжүүлээд дөрвөн жил болж байна. Энэ хүгацаанд тус үйлчилгээг авдаг байгын харилцагч байгууллагын тоо 2 дахин нэмэгдсэн ба захиалагчийн хэрэгцээнд нийцсэн урлаг ба бизнесийн шинэ агуулгыг гарган арга хэмжээг зохион байгуулдаг болсон байна.

2017 оны 12 сарын байдлаар “Хоган Ловэлс” хуулийн фирм, Францын Элчин сайдын яам, “Орифлэйм Монгол” ХХК, ХАС Банк, Нова Терра, Глобал Шейперс зэрэг байгууллагын захиалгаар хүлээн авалт, арга хэмжээг зохион байгуулж, нийт 44,425 ам.долларын санг бүрдүүлсэн байна.



ГИШҮҮНЧЛЭЛ

Хөгжлийн хөтөлбөрийн чухал хэсэг нь МУЗ-ийн гишүүнчлэлийн үйл ажиллагаа байдаг. Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчилах, уран бүтээлчийг дэмжих үйл явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн “Бид танд урлагийг ойртуулна!” МУЗ-ийн гишүүнчлэлийн арга хэмжээг “Spanish Spring” нэртэйгээр зохион байгуулж, нийт 58 хувь хүн, 12 байгууллага гишүүнээр элсүүлсэн байна. 2017 оны 12-р сарын байдлаар нийтдээ 34187 ам.долларын санхүүжилтийг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр бүрдүүлсэн болно.



МУЗ-ИЙН ТӨСЛИЙН ХАНДИВЛАГЧИД

$10,000 +

- Swiss Agency for Development and Cooperation
- АНУ дахь МУЗ
- АНУ-ын Элчин Сайдын Яам
- Делойт Онч Аудит ХХК
- Рожер Перри, Австрали улс
- Солонгосын Урлагийн Зөвлөл
- Уолтер Женкинс, АНУ
- Швейцарийн хөгжлийн агентлаг

$5,000 – $10,000

- Орифлэйм Монгол ХХК
- Тахь-Ко ХХК
- Уулархаг бүс нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих сан, Швейцарь улс
- Францын Элчин Сайдын Яам

$1000-$5,000

- Австралийн Элчин Сайдын Яам
- Ажигана Групп
- АПУ ХК
- Ариг Банк
- Гёте Институт Монгол
- Иен Финдлей Браун
- Канадын Элчин Сайдын Яам
- МЕТАА ХХК, Солонгос улс
- Монголиан Пропертис ХХК
- Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
- Нийслэлийн Соёл Урлагийн Газар
- Рэд Херо ХХК
- Төгөлдөр сан
- ХААН Банк Сан
- Хас Банк

МУЗ-ИЙН ХАМТРАГЧИД

- Архивын Ерөнхий Газар
- БСШУСЯ
- Глобал Шейперс
- Глобал Эдюкэйшн ХХК
- Говь ХК
- Гүрү Медиа ХХК
- Дижитал Контент ХХК
- Дорноговь аймгийн ЗДТГ
- D-Light ХХК
- Event Mongolia ХХК
- Занабазарын Нэрэмжит Дүрслэх Урлагийн Музей
- Зеграм Экспедишнс, АНУ
- Зориг Сан
- JCDecaux ХХК
- iCinema Кино Театр
- Inspired Living Studio
- Монгол Контент ХХК
- Монгол Наадам Цогцолбор
- Монгол Улсын Консерватори
- Монгол Улсын Филармони
- Монгол Фильм Студи
- Монголын Кино Урлагийн Зөвлөл
- Монголын Соёл Яруу Найргийн Академи
- Монголын Уран Зургийн Галерей
- Монголын Урчуудын Эвлэлийн Хороо
- Монголын Үндэсний Номын Сан
- Монголын Хүүхдийн Ордон
- Mongolia Quest ХХК
- Мөнхийн үсэг ХХК
- МУ-ын Морин Хуурын Чуулга
- Нийслэлийн Улаанбаатар Чуулга
- НЗДТГ
- Нова Терра ХХК
- Номадик Балет Продакшн
- Нью Жуулчин ХХК
- Hogan Lovells ХХК
- Олон Улсын Мод Хамгаалах Соёлын Нийгэмлэг
- On & Off Production
- Саунд оф Монголиа ХХК
- Соёл Урлагийн Их Сургууль
- Соёлын Өвийн Төв
- СУИС-ийн Дүрслэх, Дизайн Урлагийн Сургууль
- СУИС-ийн Радио Телевиз, Медиа Урлагийн Сургууль
- СХД-ийн 3-р хороо ба хорооны иргэд
- CHIC Décor ХХК
- Corporate Hotel and Convention Center
- Culture Distributer ХХК
- Таван Богд Менежмент -Xerox ХХК
- Тибу Брак, Франц улс
- Тэнгис Кино Театр
- TodaysArt Наадам, Нидерланд улс
- Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн Театр
- Улсын Их Баяр Наадам Зохион Байгуулах Хороо
- Ус цаг уур орчны судалгаа мэдээллийн хүрээлэн
- UB Inn Hotel & Gallery
- Unread ХХК
- Херитейж ХХК
- Чойжин Ламын Сүм Музей
- ШУА-ийн ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн
- ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн
- ШУТИС Геологи, уул уурхайн сургууль

МУЗ-ИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХАМТРАГЧИД

- Bloomberg TV
- Eagle TV
- Edutainment TV
- Gogo.mn
- Гэрэг сэтгүүл
- Ikon.mn
- Mongol messenger сонин
- MYOHTB
- Нийслэл Гайд сэтгүүл
- News.mn
- NTV
- Өнөөдөр сонин
- Тойм сэтгүүл
- UBS TV
- UB.life
- VTV

ХҮНДЭТ ЭРХЭМ ХАНДИВЛАГЧ РОЖЕР ПЕРРИГИЙН МЭНДЧИЛГЭЭ



Би 2017 онд МУЗ-ийн Хүндэт эрхэм хандивлагч гишүүн болж, МУЗ-ийн 2017 оны жилийн тайлангаар Та бүхэнтэй дахин мэндчилж байгаадаа баяртай байна.

Өмнө нь хэлсэнчлэн соёлын өвийг хадгалж хамгаалах асуудал бол монголчуудын хувьд нэн чухал юм. Миний бие 2017 оны 10 сард Монголд айлчлах үедээ Монголчууд соёлын өвийг хадгалж хамгаалах асуудалд өндөр ач холбогдол өгч байгааг анзаарч харсан.

Сүүлийн жилүүдэд Монгол улс эдийн засгийн хямралыг даван туулж, “Сэргээн босгох” стратегийг боловсруулж эхэлж байна. Аялал жуулчлалаар дамжуулан эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлснээр уул уурхайн салбараас хамаарах хамаарал багасна гэдэгт би найдаж байна. Аялагч, жуулчдад зочлоход таатай зүйлсийг бий болгосон тохиолдолд аялал жуулчлал хөгжих болно. Энэ нь МУЗ-ийн хувьд ч, Монголын соёлын өвийг хадгалж хамгаалахад ч чухал ач холбогдолтой гэсэн үг.

Монголын соёлын өвийг хамгаалах асуудалд Засгийн газрын оролцоо нэмэгдэж байгааг харахад таатай байгаа боловч МУЗ-ийн туршлага, мэдлэг, мэргэжлийн ур чадварыг ашиглан, туслалцаа дэмжлэгийг авч үйл ажиллагаандаа тусгах нь зүйтэй мэт санагдсан. Мөн Засгийн газраас соёлын өвийг хадгалж хамгаалахад зориулж хөрөнгө санхүү хуваарилж эхэлж байгааг харахад таатай байна.

Монголчууд өөрсдийн соёлын өв, эх нутаг, өв уламжлалаараа бахархдаг ард түмэн. Энэхүү өв уламжлалаа үргэлжлүүлэн, залуу хойч үедээ өвлүүлсээр, хүн бүр өөрийн өв соёлоо хайрлаж хамгаалахад гар бие оролцож чадвал Монголчуудын үнэт зүйлс оршсоор байх болно.

МУЗ-ийн ажилчид, гишүүд нь соёлын өвийг хадгалж хамгаалахад хүчин зүтгэдэг. Монголын ард түмэн өөрсдийн нэрийн өмнөөс ажиллаж буй ийм чадварлаг мэргэжилтнүүдтэй байгаа нь азтай хэдий боловч, уншигч Та бүхний оролцоо, дэмжлэг чухал гэдгийг байнга санаж байх хэрэгтэй.

Энэхүү мэндчилгээг уншиж буй бүх хүнд 2018 онд аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэхийн ялдамд, өнгөрсөн, одоо, ирээдүйд МУЗ-д өөрийн хувь нэмрээ оруулж байсан хүмүүст талархахын зэрэгцээ цаашид ч дэмжин хамтран ажиллахыг чин сэтгэлээсээ хүсч байгааг минь хүлээн авна уу.

МУЗ-ИЙН 2017 ОНЫ ГИШҮҮД

МУЗ-ИЙН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА:

Эрхэм хандивлагч
$5.000+
- Монголиан Пропертис ХХК / бэлэн бус/
- Ронок Файненшл солюшн, Канад улс

Ивээгч $1.000-5.000
- АПУ Трейдинг / бэлэн бус/
- Эрнст & Янг Монголиа Аудит ХХК
- Номадик Экспедишнс ХХК
- Ноён Уул Эрдэнэ ХХК /бэлэн бус/
- Сант Марал Сан
- Тайпейн Худалдаа Эдийн Засгийн Төлөөлөгчийн Газар
- Занаду Вайнс / бэлэн бус/

МУЗ-ИЙН ХУВЬ ГИШҮҮН:

Хүндэт Эрхэм Хандивлагч
US $10,000
- Рожер Перри, Австрали улс

Эрхэм хандивлагч
1,500,000MNT
- Т.Ганболд / бэлэн бус/
- Б.Доржпагма & Сара Морроу
- С.Ичинхорлоо /бэлэн бус/
- П.Цагаан
- Б.Энхбат
- Л.Энхнасан

Ивээгч 1.000.000MNT
- Б.Батсайхан
- Х.Оюунбилэг

Тэтгэгч
400,000MNT
- Б.Бадамханд
- Ч.Ганболд & О.Энхтуяа
- Н.Ганхуяг & Ч.Батгэрэл /Бэлэн бус/
- Камерон Макрей & Эки
- Д.Мөнхжин
- Б.Индра
- Б.Солонго
- Д.Хулан
- Ж.Чимэг
- Эд Жагер

Дэмжигчид
200,000MNT
- О.Азжаргал
- Ахмет Язал
- Ё. Бадрал
- М.Болд
- Габриелла Повер
- Т.Гүнчинмаа
- Д.Гэрэлтөв
- Д.Дабааням /бэлэн бус/
- З.Дэлгэрмаа
- Жулиа Питзен
- Зейнеп Язал
- Ч.Зул
- Ивана Гроллава
- Иен Кокс
- П.Мандхай
- Б.Намуун /бэлэн бус/
- Д.Оргилтуяа
- Н.Отгонбөгж
- Д.Отгонсүрэн
- Г.Сараа
- С.Солонго
- Г.Сүрэнжав/бэлэн бус/
- П.Тина
- Ж.Хоролсүрэн
- Д.Цолмон
- Ц.Энхзул
- Д.Эрдэнэбилэг
- Б.Эрдэнэчимэг

МУЗ-ИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ



Ц.Ариунаа
Продюсер, Гүрү Медиа ХХК

Ахмет Язал
Турк улсын элчин сайд

Г.Аюурзана
Зохиолч, яруу найрагч

Ё.Бадрал
Гүйцэтгэх захирал, Mongolia Quest

Б.Батсайхан
Захирал, Монголын хөрөнгө оруулалтын сан

Л.Болд
Барималч

Б.Бямбасайхан
Тэргүүн, Монголын Бизнесийн Зөвлөл

Ч.Ганболд
ТУЗ-ийн Дарга, ХАС Банк

Т.Ганболд
Үүсгэн байгуулагч Корпорейт Зочид буудал

Дэвид Спрул
Канадын Элчин Сайд

Б. Доржпагма
Захирал, Гэр Гарден ХХК

У.Жалсаа
Үүсгэн байгуулагч, Номадик Экспедишнс ХХК, төлөөлж **Б.Ундраа**, Ерөнхийлөгч, Номадик Экспедишнс ХХК

Н.Жанцанноров
МУЗ-ийн Тэргүүн

Женнифер Зимдал Галт
АНУ-ын Элчин сайд асан

Жон Белл
Гүйцэтгэх захирал, Хаан Банк

Камерон Макрей
Ерөнхий захирал, 'Tarva' хөрөнгө оруулалт, зөвлөх компани

Катерин Арнолд
Британийн Элчин Сайд

Т.Лхагвадорж
МУ-аас Сингапур улсад суугаа элчин сайд

Ж. Майзориг
Партнер, Эм-Ди-Эс & ХаанЛекс ХХК

Г.Мэнд-Ооёо
Ерөнхийлөгч, Монголын Соёл, Яруу Найргийн Академи

Ш. Норжинбат
Гүйцэтгэх захирал, Делоит Онч Аудит ХХК

Ж.Оджаргал
Ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг

Х.Отгонтуяа
Тэргүүн, Төгөлдөр сан

С.Оюун
Тэргүүн, Зориг Сан

Ж.Оюунгэрэл
ТУЗ-ийн Дарга, Петровис

Л.Сумати
Захирал, Сант Марал Сан

Э.Туул
Ерөнхийлөгч, Ажигана Групп

У Сун
БНСУ-ын Элчин Сайд

Уолтэр Женкинс
МУЗ-ийн дэд тэргүүн, Ерөнхийлөгч, Инклюсив Солюшнс ХХК

П.Цагаан
Гүйцэтгэх захирал, Степпкупер ХХК

Элизабет Барсак
Франц Улсын Элчин Сайд

Б.Энхбат
Захирал, Эм Ди Эс & Хаан Лекс ХХН

МУЗ-ИЙН ХОРООДЫН ГИШҮҮД

ГҮЙЦЭТГЭХ ХОРОО

Дарга:
Б.Энхбат
Захирал, Эм Ди Эс & Хаан Лекс ХХН

Гишүүд:
Ц.Ариунаа
Продюсер, Гүрү Медиа

Б.Бямбасайхан
Тэргүүн, Монголын Бизнесийн Зөвлөл

Н.Жанцанноров
МУЗ-ийн Тэргүүн

Ш. Норжинбат
Гүйцэтгэх захирал, Делоит Онч Аудит ХХК

Л.Сумати
Захирал, Сант Марал Сан

П.Цагаан
Гүйцэтгэх захирал, Степпкупер ХХК

Уолтэр Женкинс
МУЗ-ийн Дэд тэргүүн, Ерөнхийлөгч, Инклюсив Солюшнс ХХК

ХӨГЖЛИЙН ХОРОО

Дарга:
Б.Бямбасайхан
Тэргүүн, Монголын Бизнесийн Зөвлөл

Гишүүд:
Ё.Бадрал
Гүйцэтгэх захирал, Mongolia Quest

Ч.Ганболд
ТУЗ-ийн Дарга, ХАС Банк

Н.Жанцанноров
МУЗ-ийн тэргүүн

Х.Отгонтуяа
Тэргүүн, Төгөлдөр Сан

Ж.Оюунгэрэл
ТУЗ-ийн Дарга, Петровис ХХК

Р.Туяацэцэг
Ерөнхий захирал, Монре Импекс ХХК

ХӨТӨЛБӨРИЙН ХОРОО

Дарга:
Л.Болд
Барималч

Гишүүд:
Г.Аюурзана
Яруу найрагч

Б.Баяраа
Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга, СУИС

Н.Ганхуяг
Урлагийн менежер

Г.Энхбат
Захирал, Соёлын Өвийн Төв

МОНГОЛЫН УРЛАГИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛТНУУД



О.Одгэрэл
Гүйцэтгэх захирал
odgerel@artscouncil.mn

Б.Номинтуяа
Урлаг ба Хөгжлийн асуудал эрхэлсэн гүйцэтгэх дэд захирал
arts@artscouncil.mn

Х.Оюундарь
Олон Нийтийн Урлагийн Боловсролын Хөтөлбөрийн захирал
culture@artscouncil.mn

Д.Баянмөнх
Соёлын Өвийн Хөтөлбөрийн захирал
heritage@artscouncil.mn

Б.Оюунсүрэн
Маркетинг, олон нийттэй харилцах хөтөлбөр зохицуулагч
marketing@artscouncil.mn

Д.Оюунсүрэн
Ерөнхий Нягтлан бодогч
grants@artscouncil.mn

Б.Батгэрэл
Хөтөлбөрийн ажилтан
associate@artscouncil.mn

Г.Гэрэлсүрэн
Хөтөлбөрийн ажилтан
redger@artscouncil.mn

Т.Ганцэцэг
Хөтөлбөрийн ажилтан,
Улаан гэр галерейн менежер
/2011-2018/

Д.Болорцэцэг
Хөтөлбөрийн туслах
/2012-2017/